



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/123

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 06 дугаар “Сумын 2024 оны төсөв батлах тухай” тогтоол, сумын Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/42 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:


1. Шивээговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 6-12 дугаар ангийн суралцагчдын дунд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис, электрон тамхины хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулсугай.

2. Сургалтын удирдамжийг 1 дүгээр, зарцуулагдах төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалтад зарцуулагдах 200,000 (хоёр зуун мянга) төгрөгийг Хөтөлбөрт суурилсан арга хэмжээний зардлаас зарцуулахыг Ахлах нягтлан бодогч (Л.Туяа)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Ч.СУГАРМАА



2024 оны 10-р сарын 10-ны өдрийн  
11/23 дугаар захирамжийн 1-р хавсралт



**МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨЛӨХ БОДИС,  
ЭЛЕКТРОН ТАМХИНЫ ХОР УРШИГ, ТҮҮНЭЭС УРЬДЧЛАН СЭРГИЙЛЭХ  
СУРГАЛТЫН УДИРДАМЖ**

**Зорилго:** Мансууруулах бодис, электрон тамхины хор уршгийг талаарх мэдээллийг өсвөр насны хүүхдүүдэд сурталчлан таниулж, урьдчилан сэргийлэхэд оршино.

**Зорилт:**

- Электрон тамхины хор уршгийг таниулах
- Мансууруулах бодисын талаарх мэдээллийг өгөх

**Сэдэв:**

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис, электрон тамхины хор уршиг

**Хамрах хүрээ:**

- Шивээговь сумын Ерөнхий боловсролын 3-р сургуулийн 6-12 ангийн суралцагчид

**Хугацаа:**

- Ахлах анги 10 сарын 10-нд 17 цагт
- Дунд анги 10 сарын 10-нд 10 цагт

**Хаана:** Шивээговь сумын соёлын төвд

**Зохион байгуулагч:**

- Шивээговь сумын ЗДТГ, Цагдаагийн тасаг

2024 оны 10-р сарын 10-ны өдрийн  
11723 дугаар захирамжийн 2-р хавсралт



**СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ЗАРЦУУЛАГДАХ ТӨСӨВ**

2024.10.02

№	Нэр	Тоо (ширхэг)	Ширхэгийн мөнгөн дүн	Нийт
1	гарын авалга	200ш	1000	200000
<b>Нийт</b>				<b>200000</b>

Төсөв гаргасан:

НБМЭРГЭЖИЛТЭН:

Б.АЛТАНСҮХ